

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“ОРХОН АЙМГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ” АУДИТЫН ТАЙЛАН



Улсын төсөвт 9,394.2 сая төгрөг төвлөрүүлж, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 110.3 хувиар биелүүлэн, төсвийн зарлагын гүйцэтгэл 86.1 хувьтай байна.

**Орхон аймаг
2018 он**

Аудитын тайланг бэлтгэсэн:	АГУУЛГА	2
	Товчилсон үгийн тайлбар	3
Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:	5
Дарга, Тэргүүлэх аудитор :	Ц.Нармандах	5
	Бүлэг-1. Орон нутгийн төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, хянах шаардлагатай байна.	5
	<ul style="list-style-type: none"> ➢ Сангийн яамны тогтоосон хязгаарыг харгалзан үзэж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх шаардлагатай байна. ➢ Аймгийн төсвийн орлогыг 134.6 сая төгрөг, зардлыг 1,563.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн ИТХ-аар баталсан байна. 	6
Аудитын менежер:	Б.Эрдэнэ	10
	Бүлэг-2. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 9 сарын төлөвлөгөө 6,265.4 сая төгрөгөөр давж, гүйцэтгэл 110.3 хувьтай байна.	10
Аудитор	Б.Буян-Ундрах	10
	<ul style="list-style-type: none"> ➢ 2018 оны орон нутгийн орлого ба тусламжийн төлөвлөгөө бүрэн хэрэгжих боломжтой байна. ➢ Замын цагдаагийн бэлэн бус торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна. 	13
2018 оны 11 дүгээр сар	О.Гантуяа	13
	Бүлэг-3. Аймгийн 2018 оны 09 сарын байдлаарх төсвийн зардлын гүйцэтгэл 86.1 хувьтай байна.	13
Уг тайланг audit.mn цахим хуудаснаас үзнэ үү.	<ul style="list-style-type: none"> ➢ Төсвийн хуваарийг бодитой төлөвлөөгүйгээс зарим зардлын гүйцэтгэл хэмнэлттэй гарсан байна. ➢ Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАУХА тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. 	16
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж, тодруулах, лавлах зүйл байвал 70353088, 70350757, 70355805 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг-4. ТЕЗ-ын төсөл, хөтөлбөрүүдийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлтэй нийцүүлэн баталсан хэдий ч хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.	22
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	<ul style="list-style-type: none"> ➢ Аймгийн 2018 оны төсвийг батлахдаа ТЕЗ-ийн хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж, төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулаагүй байна. ➢ ТЕЗ-ын төсөл, хөтөлбөрүүдийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлтэй нийцүүлэн баталсан байна. ➢ Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна. 	24
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	Дүгнэлт	
	Зөвлөмж	24
	Холбогдох байгууллагын санал	24
	Тэргүүлэх аудиторын тушаал	26
		27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ҮХЭХ	Үл хөдлөх эд хөрөнгө
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ОАТ	Орлогын албан татвар
ААН	Аж ахуй нэгж
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХББЗА	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ТББ	Төрийн бус байгууллага
ЗД	Засаг дарга

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний 38 дахь заалтыг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сан болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиудын хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, нэгдсэн дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит гүйцэтгэнэ. Үүнд:

- 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх,
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх,
- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх,
- ТЕЗ болон ТТЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн ТЕЗ, ТТЗ-дын 2018 оны 09 дүгээр сарын байдлаарх санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын болон Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- Аймгийн ИТХ-ын тогтоол

Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдан, менежер Б.Эрдэнэ чанарын хяналт хийж, аудитор Б.Буян-Ундрах, О.Гантуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл:

Орхон аймгийн 2018 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, Засаг даргын нөөц сан, орон нутгийн хөгжлийн сан, нийгмийн халамжийн сан, орон нутагт хэрэгжүүлж байгаа сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, байгаль хамгаалах сан, Эрдэнэт сан, орон нутгийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, төсвийн байгууллагууд, тусгай зориулалтын шилжүүлэгтэй ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв нийт аймгийн хэмжээгээр 94 байгууллагуудыг санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуульд Орхон аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 44,300.7 сая төгрөг, суурь зарлагыг 20,472.8 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 12,016.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Орхон аймгийн 2018 оны орлого зарлагын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 сарын 01-ний өдрийн 9/04 дугаар тогтоолоор 82,409.4 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна. Үүнээс: татварын орлогыг 43,800.8 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 634.5 сая төгрөгөөр, тусламжийн орлогыг 37,974.1 сая төгрөгөөр баталсан бол 69281.6 сая төгрөгийг урсгал зардалд, 13127.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар тусгасан байна.

Харин аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10/02 дугаар тогтоолоор 6,021.6 сая төгрөгөөр төсөвт тодотгол хийж баталсан байна.

Аймгийн төсвөөс 2018 оны төсвийн жилд улсын төсөвт төвлөрүүлэх орлогын оны эхний 09 сарын төлөвлөгөө 10,669.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 9,394.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, хянах шаардлагатай байна.

1.1 Сангийн яамны тогтоосон хязгаарыг харгалзан үзэж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх шаардлагатай байна.

Аймгийн төсвийн зарлагын хяналтын хуудсыг батлагдсан төсөвтэй харьцуулж үзэхэд:

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Хязгаар	Санал	Хязгаар саналын зөрүү	Сангийн яамнаас хянасан	Санал хяналтын зөрүү	Батлагдсан төсөв	Хяналт, батлагдсан төсвийн зөрүү
1	АИТХ	149.4	772.5	(623.0)	233.0	539.4	820.4	(587.38)
2	СИТХ	129.1	324.9	(195.8)	130.2	194.7	-	130.19
3	АЗДТГ	1,004.3	1,940.0	(935.8)	1,024.3	915.7	1,861.4	(837.11)
4	СЗДТГ	1,425.6	2,845.5	(1,419.9)	1,451.8	1,393.8	-	1,451.78
5	СХАА	89.8	139.8	(50.0)	91.1	48.7	112.2	(21.06)
6	ОНӨГ	143.0	414.6	(271.6)	146.2	268.4	211.3	(65.15)
7	ХЗА	110.2	161.7	(51.5)	128.8	32.9	149.8	(21.02)
8	Халамжийн сан	8,447.8	8,491.3	(43.5)	8,265.1	226.2	9,864.7	(1,599.57)
9	Ойн анги	27.8	72.1	(44.3)	45.5	26.6	52.9	(7.39)
10	БОАЖГ	115.7	167.9	(52.2)	131.0	36.9	146.3	(15.29)
11	БО нөхөн сэргээх	672.7	1,309.1	(636.4)	752.8	556.3	752.8	-
12	Хотын нийтийн тээвэр	845.9	1,845.9	(1,000.0)	845.9	1,000.0	845.9	-
13	Хот тохижуулах газар	1,891.6	3,415.5	(1,523.9)	2,035.1	1,380.3	2,135.8	(100.68)
14	Мал эмнэлгийн үйлчилгээ	42.4	90.0	(47.6)	38.9	51.1	-	38.88
15	Замын сан	607.7	702.0	(94.3)	702.0	-	639.0	63.00
16	Ахмадын хорооны төсөв	64.4	91.0	(26.6)	64.4	26.6	64.4	-
17	Жолоочийн хариуцлагын даатгал	70.2	78.0	(7.8)	78.0	-	71.0	7.00
Дүн		15,837.6	22,861.9	-7,024.2	16,164.2	6,697.7	17,728.0	-1,563.8

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 оны төсвийн төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжийн 4.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийн санал боловсруулахдаа Засгийн газраас баталсан төсвийн зарлагын хязгаар, дунд хугацаанд төсвийн зарлагад баримталж буй бодлого, чиглэлд нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх ба төсвийн бодит боломжит нөөцөөр тухайн салбарын зорилтыг хамгийн үр дүнтэйгээр хангахыг чухалчилна.” гэж заасан байтал зарлагын хязгаараас 7,024.2 сая төгрөгөөр илүү дүнгээр саналаа хүргүүлсэн байна. Саналыг сангийн яамнаас хянаад төсвийн зарлагыг 16,164.2 сая төгрөгөөр тогтоосон боловч ИТХ-аар 17,728.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Аймгийн төсвийн зарлагын хяналтын хуудсыг батлагдсан төсөвтэй харьцуулж
үзэхэд:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Суурь орлого /Санал/	Суурь орлого /Хянасан/	Зөрүү	Нийт орлого /Санал/	Нийт орлого /Хянасан/	Зөрүү	Батлагдсан төсөв	Хянасан нийт орлого батлагдсан төсвийн зөрүү
Орлогын албан татвар	26,410.00	28,475.00	(2,065.00)	26,490.00	28,475.00	(1,985.00)	27,845.00	630.00
Өмчийн татвар	4,905.00	5,311.00	(406.00)	5,591.00	5,311.00	280.00	6,050.60	(739.60)
Бараа үйлчилгээний татвар	660.00	710.00	(50.00)	702.00	710.00	(8.00)	710.00	-
Бусад татвар	5,243.00	5,395.30	(152.30)	9,276.20	9,195.30	80.90	9,195.30	-
Татварын бус орлого	359.50	609.50	(250.00)	359.50	609.50	(250.00)	634.50	(25.00)
Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	37,577.50	40,500.80	-2,923.30	42,418.70	44,300.80	-1,882.10	44,435.40	-134.60

Сангийн яамнаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх суурь орлогын саналыг хянахдаа 2,923.3 сая төгрөгөөр, нийт орлогын саналыг 1,882.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна. 2018 оны батлагдсан төсвийг сангийн яамнаас хянасан нийт орлогоос 134.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

1.2 Аймгийн төсвийн орлогыг 134.6 сая төгрөг, зардлыг 1,563.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн ИТХ-аар баталсан байна.

1.2.1 Сангийн яамаар хянагдаж, УИХ-аар батлагдсан орон нутгийн орлогыг 134.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/04 тоот тогтоолоор 2018 оны төсвийн нийт орлогыг 82,409.4 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүнээс орон нутгийн төсвийн орлого 44,435.3 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 3,504.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 34,220.5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж буй байгууллагын өөрийн орлого 248.6 сая төгрөг, урсгал зардлыг 69281.6 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 13127.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

УИХ-аас баталж, Сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2018 оны Орхон аймгийн орон нутгийн төсвийн нийт орлогыг 44,300.7 сая төгрөг, татварын орлогыг 43,691.3 сая төгрөг, татварын бус орлогыг 609.4 сая төгрөгөөр хянасныг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/04 дүгээр тогтоолоор нийт орлогыг 44,435.3 сая төгрөг, татварын орлогыг 43,800.8 сая төгрөг, татварын бус орлогыг 634.4 сая төгрөг болгон орлогыг 134.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн орлогын төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ		УИХ-аар баталсан нийт орлого	Өөрчлөлт	АИТХ-ын 2017.12.01 9/04 тоот тогтоол
Нийт орлого		44,300.7	134.6	44,435.3
Урсгал орлого		44,300.7	134.6	44,435.3
1	Татварын орлого	43,691.3	109.6	43,800.9
2	Орлогын албан татвар	28,475.0	-630.0	27,845.0
3	Хувь хүний орлогын албан татвар	30,725.0	-630.0	30,095.0
3.1	Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	28,400.0	-480.00	27,920.0
3.2	Үйл ажиллагааны орлого	240.0	-	240.0
3.3	Хөрөнгө борлуулсны орлого /ҮХЭХ борлуулсны 2%-н татвар /	640.0	-150.0	490.0
3.4	Хөрөнгийн орлого / Хадгаламжин хүүгийн орлого/	1,035.0	-	1,035.0
4	Шууд бус орлого /Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татвар /	410.0	-	410.0
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-2,250.0	-	-2,250.0
6	Өмчийн татвар	6,021.0	739.6	6,760.6
6.1	Үл хөдлөх эд хөрөнгийн татвар / 0.6% болон иргэдийн өмчилж авсан газрын татвар/	5,293.0	739.6	6,032.6
6.2	Бууны албан татвар	18.0	-	18.0
6.3	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	710.0	-	710.0
7	Бусад татвар /төлбөр хураамж /	850.0		850.0
7.1	Улсын тэмдэгтийн хураамж	350.0	-	350.0
7.2	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	500.0	-	500.0
8	Газрын төлбөр	8,300.0	-	8300.0
8.1	Газрын төлбөр	8,300.0	-	8300.0
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	45.3	-	45.3
9.1	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	19.3	-	19.3
9.2	Ус, рашаан ашигласны төлбөр	21.0	-	21.0
9.3	Ойн нөөц ашигласны төлбөр	5.0	-	5.0
10	Татварын бус орлого	609.4	25.0	634.4
10.1	Төсөвт байгууллагын өөрийн орлого	59.4	-	59.4
10.2	Хүү, торгуулийн орлого	550.0	25.0	575.0

Сангийн яамнаас хянасан тоог нэмэгдүүлэн батлахдаа Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг 480.0 сая төгрөг, хөрөнгө борлуулсны /ҮХЭХ–ийн 2.0%-ийн татвар/ орлогыг 150.0 сая төгрөгөөр хасаж, Үл хөдлөх эд хөрөнгийн татвар /0.6% болон иргэдийн өмчилж авсан газрын татвар/ орлогыг 739.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

1.2.2 Аймгийн ИТХ-ын 2018 оны 02 дугаар сарын 23-ны 10 дугаар хуралдааны 10/02 тогтоолоор төсөвт 6,021.6 сая төгрөгийн тодотгол хийсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.” 34.2.1-т “дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон;” 34.2.2-т “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон;” 34.2.-т “энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах” гэсэн заалтуудыг зөрчиж тодотгол хийсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 02 дугаар сарын 23-ны 10 хуралдааны 10/02 тогтоолоор 2018 оны аймгийн орон нутгийн төсвийн зардлыг урьд оны шилжих үлдэгдэл 5,869.3 сая төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдэл 137.2 сая төгрөг, ОНХС-ийн орлого 15.1 сая төгрөг нийт 6021.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Баян-Өндөр сум.

Баян-өндөр сумын 2017 оны 12 сарын 20-ны ээлжит 7-р хуралдааны 06 дугаар тогтоолоор Баян-өндөр сумын 2018 оны төсвийг батлахдаа ИТХ-ын урсгал зардлыг 93.5 сая төгрөг, ЗДТГ-ын урсгал зардлыг 1028.5 сая төгрөг, ЗДНөөц санг 40.0 сая төгрөг нийт 1162.1 сая төгрөгөөр баталсан. ОНХС-ийн санхүүжилтийг аймгийн ОНХС-аар хуваарилсан 753.8 сая төгрөг, шилжих үлдэгдэл 23.3 сая төгрөг нийт 806.9 сая төгрөгөөр баталсан байна.

2018 оны 03 сарын 05-ны ээлжит 8-р хуралдааны 5 дугаар тогтоолоор Баян-өндөр сумын ИТХ-ын урсгал зардлыг 76.5 сая төгрөг, ЗДТГ-ын урсгал зардлыг 543.8 сая төгрөг, нийт 620.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсөв тодотгосон байна.

Санхүүгийн дэмжлэгийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Санхүүжүүлэх байгууллага нэр	СИТХ-аас баталсан 2017.12.20-ний 06 тоот тогтоол	Өөрчлөлт	СИТХ-аас баталсан 2018.03.05-ны 05 тоот тогтоол
1	Баян-өндөр сумын ИТХ	93.5	76.5	170.0
2	Баян-өндөр сумын ЗДТГ	1028.5	543.8	1572.3
	Дүн	1122.0	620.3	1742.3

Жаргалант сум.

Жаргалант сумын 2018 оны төсвийг СИТХ-ын 2017 оны 12 сарын 20-ны ээлжит 7-р хуралдааны 11 дүгээр тогтоолоор ИТХ-ын урсгал зардлыг 71.2 сая төгрөг, ЗДТГ-ын урсгал зардлыг 339.0 сая төгрөг, Багт 70.7 сая төгрөг нийт 480.9 сая төгрөгөөр баталсан. ОНХС-ийн санхүүжилтийг аймгийн ОНХС-аар

хуваарилсан 752.4 сая төгрөг, шилжих үлдэгдэл 1.4 сая төгрөг нийт 753.8 сая төгрөгөөр баталсан байна.

2018 оны 03 сарын 28-ны ээлжит 9-р хуралдааны 01 дүгээр тогтоолоор Жаргалант сумын ИТХ-ын урсгал зардлыг дотор нь зардал хооронд гүйлгэн цалин, НДШ-ийн зардлаас 0.5 сая төгрөгийг хасаж мэдээллийн технологи зардалд, ЗДТГ-ын урсгал зардлыг 131.2 сая төгрөгөөр нэмж, Багийн зардлаас 5.4 сая төгрөгийг хасаж нийт 125.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсөв тодотгосон байна.

Санхүүгийн дэмжлэгийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөг/

д/д	Санхүүжүүлэх байгууллага нэр	СИТХ-аас баталсан 2017.12.20-ний 11 тоот тогтоол	Өөрчлөлт	Өөрч СИТХ-аас баталсан 2018.03.28-ны 01 тоот тогтоол
1	Жаргалант сумын ИТХ	71.2	дотор нь өөрчлөлт	71.2
2	Жаргалант сумын ЗДТГ	339.0	131.2	470.2
3	Жаргалант Баг	70.7	-5.4	65.3
Дүн		480.9	125.8	606.7

1.2.3 Хөрөнгө оруулалтын ажлыг бодитой төлөвлөөгүйгээс, төсөв батлагдсанаас хойш ТАХ-ний нэршил байршил өөрчлөгдөж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ТАХ-г санхүүжүүлэхээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

2018 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар 253 төсөл арга хэмжээг 14114.6 сая төгрөгөөр санхүүжүүлж гүйцэтгэхээр төлөвлөж, АИТХ-ын 2017 оны 12 сарын 01-ний 9/04 дүгээр тогтоолоор баталсан байна. Үүнд: Хөрөнгө оруулалтын 196 ажлын 11924.8 сая төгрөг, шилжих үлдэгдлээр санхүүжигдэх 11 ажлын 797.9 сая төгрөг, Байгаль хамгаалах арга хэмжээний хөрөнгө оруулалтаар 41 ажлын 752.8 сая төгрөг, Авто замын сангаар 5 ажлын 639.0 сая төгрөг тус бүр санхүүжигдэхээр батлагдсан байна

Аймгийн ИТХ-ын 2018 оны 02 сарын 23-ны өдрийн 10/05 тоот тогтоолоор аймгийн ИТХ-ын ээлжит 9 хуралдааны 9/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан 5 ажлын нэршлийг өөрчилжээ.

Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 05 дугаар сарын 04-ны 37 дугаар, ИТХ-ын 2018 оны 06 дугаар сарын 06-ны 11/03 дугаар тогтоолуудаар хөрөнгө оруулалтын дараах төсөл арга хэмжээний нэр өөрчилсөн байна.

Нэр өөрчлөгдсөн ТАХ-ний жагсаалт

/сая төгрөг/

1.1.21	Эрдэнэ багийн 11-р цэцэрлэгийг уурын зуухтай болгох	35.0	35.0	Эрдэнэ багийн 11-р цэцэрлэгийн гадна шугамын ажил	35.0	ТАХ-ний Зураг төсвийн нэр зөрсөн.
2.1.15	Яргуйт баг Хөтөлийн 1-37-р гудамжны гэрэлтүүлэг хийх	24.0	24.0	Яргуйт баг Овоотын 10-12-р гудамжны гэрэлтүүлэг хийх	24.0	ТАХ-ний нэрийг зөрүүлж бичсэн.
2.1.16	Даваат баг Овоотын 10-12-р гудамжны гэрэлтүүлэг хийх	14.4	14.4	Даваат баг Манханы 17-р гудамжны гэрэлтүүлэг хийх	14.4	
2.3.9	Аймгийн ЗДТГ бараа үйлчилгээний зардал	49.9	49.9	Аймгийн ИТХ-ын байгууллагын зочид төлөөлөгч, иргэдэд хүндэтгэл үзүүлэх бэлэг дурсгалын зүйл худалдан авах зардал	49.9	

Эдгээр төсөл арга хэмжээний нэр өөрчлөгдөхөд ажлын зураг, төсөв өөрчлөгдөнө. Гэвч дахин зураг төсөв хийхгүйгээр хуучин зураг төсвөөр хийгдэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана.” гэж заасныг зөрчсөн байна.

Төсөв батлагдсанаас хойш 183.1 сая төгрөгийн 12 ТАХ-ний зураг төсөв хийгдсэн байна. Тухайлбал:

- Эрдэнэ багийн байрны засварын ажил
- Зэст багийн 6-р сургуулийн гадна талбайн тохижилт
- Согоот багийн 6-15-р байрны өмнөх явган хүний зам шинэчлэх
- Уурхайчин багийн 3-17-р байрны урд талын явган хүний зам шинэчлэх
- Шанд багийн 20-27-р гудамжны нарийн зөргийн явган хүний зам хийх

Бүлэг. 2 Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 9 сарын төлөвлөгөө 6,265.4 сая төгрөгөөр давж, гүйцэтгэл 110.3 хувьтай байна.

2.1 2018 оны орон нутгийн орлого ба тусламжийн орлогын төлөвлөгөө бүрэн хэрэгжих боломжтой байна.

Аймгийн төсөвт 66,826.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, гүйцэтгэл 110.3 хувьтай байна. Татварын орлогын төлөвлөгөө 116.7 хувиар, татварын бус орлогын төлөвлөгөө 103.5 хувиар давж биелсэн байна.

Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 9 сарын байдлаар харуулбал:
/сая төгрөг/

Орлогын үзүүлэлт	2018 он		
	9 сарын төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
Нийт орлого	60561.3	66826.7	110.3
Урсгал орлого	60561.3	66826.7	110.3
Татварын орлого	31284.4	36519.0	116.7
Орлогын албан татвар	19485.0	22601.4	116.0
Хувь хүний орлогын албан татвар	21735.0	24749.2	113.9
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-2250.0	-2147.8	95.5
Хөрөнгийн албан татвар	5186.6	6708.4	129.3
Бусад татвар, төлбөр хураамж	6612.8	7209.2	109.0
Татварын бус орлого	29276.9	30307.7	103.5
Нийтлэг татварын бус орлого	1150.2	2969.3	258.2
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	28126.7	27338.4	97.2

Орхон аймаг 2018 оны төсвийн орлогыг аймгийн ИТХ-ийн 2017 оны 12-р сарын 01-ний өдрийн хуралдаанаар татварын орлогыг 44,435.3 сая төгрөгөөр баталсан байна. 2018 оны 02 сарын 23-ны 10/02 тогтоолоор төсөвт тодотгол хийхэд орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр авч үзвэл 13 нэр төрлийн татварын орлого 121.1 хувь буюу 6,843.5 сая төгрөгөөр давж биелэн, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 47.0 хувиар буюу 8,821.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Татварын болон татварын бус орлогыг нэр төрлөөр харуулбал:
/сая төгрөг/

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	9 сарын төлөвлөгөө өссөн	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	27920.0	20120.0	21769.3	1649.3	108.2
2	Үйл ажиллагааны орлого	240.0	155.0	175.4	20.4	113.2
3	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	1035.0	772.4	1641.8	869.4	212.6
4	Хөрөнгө борлуулсны орлого	490.0	380.0	568.7	188.7	149.7
5	Шууд бус орлого	410.0	307.6	593.7	286.1	193.0
6	ХХОАТ-ын буцаалт	-2250	-2250	-2147.7	102.3	95.5
7	Үл хөдлөх хөрөнгийн татвар	6032.5	4482.5	5869.0	1386.5	130.9
8	Бууны татвар	18.0	4.0	11.9	7.9	297.5

9	АТБӨЯХАТатвар	710.0	700.0	827.4	127.4	118.2
10	Улсын тэмдэгтийн хураамж	350.0	260.0	271.0	11	104.2
11	ТТАМ-н ОАТ	19.3	16.8	7.9	-8.9	47.0
12	Хог хаягдлын хураамж	500.0	365.0	343.4	-21.6	94.1
13	Газрын төлбөр	8300.0	5950.0	6399.2	449.2	107.5
14	Бусад татвар			149.8	149.8	0.0
15	Ус рашааны нөөц ашигласны	21.0	16.0	37.7	21.7	235.6
16	Ойн нөөц ашигласны	5.0	5.0	5.6	0.6	112.0
17	Хүүгийн орлого /Төсөвт байг өөрийн/	59.5	810.0	1825.3	1015.3	225.3
18	Торгуулийн орлого	575.0	340.0	928.4	588.4	273.1
	Дүн	44435.3	32434.3	39277.8	6843.5	121.1

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь задлан үзвэл түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого тасарч, бусад орлогууд давж биелсэн байна. Тасарсан болон давсан орлого тус бүрийн шалтгааныг тогтооход дараах байдалтай байна. Үүнд:

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг оны эхний 9 сарын байдлаар 16.8 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 7.9 сая төгрөг буюу 47.0 хувиар тасарсан нь тухайн орлого төвлөрүүлдэг 8 аж ахуйн нэгж байдаг бөгөөд 1 аж ахуйн нэгж орлого төвлөрүүлж бусад 7 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй байна.

Хөрөнгийн орлого/хадгаламжийн хүүгийн орлого/-ыг оны эхний 9 сарын байдлаар 772.4 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 1,641.8 сая төгрөг төвлөрүүлж 869.4 сая төгрөг буюу 112.5 хувиар давсан нь уг татварын төрөл 2017 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд урьд онд арилжааны банкууд төв банкандаа төвлөрүүлж байсан. Харин 2018 оноос орон нутагт хүүгийн орлогыг төвлөрүүлснээс давсан байна.

Хөрөнгө борлуулсны татварын орлогыг оны эхний 9 сарын байдлаар 380.0 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 568.7 сая төгрөг төвлөрүүлэн 188.7 сая төгрөг буюу 149.7%, **Бууны албан татварын** төлөвлөгөөг 4.0 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 11.9 сая төгрөг төвлөрүүлэн 7.9 сая төгрөг буюу 297%, **Хүү торгуулийн** орлогын төлөвлөгөөг 340.0 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 928.4 сая төгрөг буюу 366% тус тус давсан байна.

Эдгээр хөрөнгө борлуулсны татварын орлого, бууны албан татвар, хүү торгуулийн орлогуудыг бодитой төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 9 сарын төлөвлөгөө 16.0 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 37.7 сая төгрөг орсон нь Эрдэнэт ДЦС худаг, гадаргын ус ашигласны төлбөрт дангаараа 34.7 сая төгрөг төлсөнөөр 235.6 хувиар давсан байна.

Бусад татвар: Бусад татварын төлөвлөгөө батлагдаагүй байтал 149.8 сая төгрөг орсон байна. Тухайн орлого нь татварын хүү, торгуулийн орлого орсон байна.

Сангийн сайдын 2015 оны 01-р сарын 20-ны 7 дугаар тушаалаар батлагдсан эдийн засгийн ангилалд татварын хүү торгуулийн орлого гэсэн эдийн засгийн ангилал байхгүйгээс болж татварын ангилалд хамруулан бүртгэсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого:-ын төлөвлөгөөг 810.1 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 1,825.3 сая төгрөг орж, 1,015.2 сая төгрөг буюу 125.3 хувиар давсан байна. Энэ нь Эрдэнэт сангийн орлого төсөвт байгууллагын орлогын төлөвлөгөөн дээр нэмэгдсэн байна. Эрдэнэт санд төлөвлөгдөөгүй 6 нэр төрлийн 590.5 сая төгрөгийн орлого орсноос төлөвлөгөө давж биелсэн байна.

Бусад орлого: Төлөвлөгдөөгүй орлогод гүйцэтгэлээр 215.5 сая төгрөг орсон нь Эрдэнэт сангийн үйл ажиллагааны санхүүжилтийн үлдэгдэл байна.

Үүнээс дүгнэхэд: татварын болон татварын бус орлогыг бодитой төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө хэт давж биелж байна. Мөн татварын бус орлогод төлөвлөгдөөгүй орлогууд орсноос жилийн төлөвлөгдсөн орлого давж биелсэн байна.

2018 оны татварын орлогыг 44,435.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Татварын орлого 9 сарын гүйцэтгэлээр 39,277.8 сая төгрөг байгаа нь бүтэн жилийн гүйцэтгэл 88.3%-тай байна. Үүнээс харахад орон нутгийн төсвийн орлого бүрэн биелэх боломжтой байна.

2.2 Замын цагдаагийн бэлэн бус торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

2018 онд бэлэн бус торгуулийн системээр давхардсан тоогоор 14089 иргэнд 988.0 сая төгрөгийн торгууль ноогдуулсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн орлогод 221.6 сая төгрөгийн орлого төвлөрч 766.4 сая төгрөгийн орлого төвлөрөөгүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2013 оны 388 дугаар тогтоолоор баталсан “Бэлэн бус торгуулийн систем нэвтрүүлэх түр журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Зөрчил гаргасан этгээд нь ногдуулсан торгуулийг 15 хоногийн дотор заасан дансанд төлөх үүрэгтэй”, 4.2-т “Торгуулийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдол бүрт Захиргааний хариуцлагын тухай хуулийн 32.3-т заасны дагуу 20.0 мянган төгрөгөөр торгох арга хэмжээ авна” гэж заасан байна.

Иймд орлогыг тухайн онд орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлж ажиллах бүрэн боломжтой байна.

Бүлэг.3 Аймгийн 2018 оны 09 сарын байдлаарх төсвийн зардлын гүйцэтгэлээр 86.1 хувьтай байна.

3.1 Төсвийн хуваарийг бодитой төлөвлөөгүйгээс зарим зардлын гүйцэтгэл хэмнэлттэй гарсан байна.

Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 86.1 хувь буюу 62079.7 сая төгрөгийн зарлагын санхүүжилтээс 3.7 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд,

15 хувийг хөрөнгийн зардалд, 19.3 хувийг бараа үйлчилгээний зардалд, 30.9 хувийг цалин хөлсөнд, 31.1 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт зарцуулсан байна.

2018 оны 09 сарын байдлаарх төсвийн зарлагын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	Тодотгосон төсөв /9 сарын байдлаар/	Урьдчилсан гүйцэтгэл 9 сарын 30	Зөрүү
Б	1	1	3=2-1
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,036.3	62,079.9	9956.4
УРСГАЛ ЗАРДАЛ	56,496.5	52,794.1	3702.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,990.9	33,515.5	1475.4
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	19,407.3	19,215.0	192.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,348.6	2,329.6	19.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,182.1	1,637.2	544.9
Хангамж, бараа материалын зардал	887.8	785.2	102.6
Нормативт зардал	1,625.8	1,273.9	352.0
Эд хогшил, урсгал засварын зардал	322.1	286.9	35.1
Томилолт, зочны зардал	100.3	70.5	29.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,855.9	5,801.9	54.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,761.3	5,739.7	21.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6.7	2.0	4.7
Даатгалын үйлчилгээ	33.4	31.8	1.6
Тээврийн хэрэгслийн татвар	7.9	3.6	4.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2.7	2.1	0.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9.2	5.3	3.9
Газрын төлбөр	33.7	17.1	16.6
Банк, СБ-ын үйлчилгээний хураамж	1.0	0.2	0.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,261.0	2,115.3	145.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,074.3	1,991.2	83.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	186.7	124.1	62.6
ХҮҮ			0.0
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	636.6	326.3	310.3
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр			0.0
ТАТААС	636.6	326.3	310.3
Төрийн өмчит байгууллагад олгох татаас			0.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас			0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,869.0	18,952.3	1916.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,669.2	9,394.3	1274.9
Засгийн газрын дотоод шилжүүлэг			0.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	10,669.2	9,394.3	1274.9
Бусад урсгал шилжүүлэг	10,199.8	9,558.0	641.7
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж			0.0
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,366.0	7,356.0	10.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17.8	7.1	10.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	680.9	570.5	110.4
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт			0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	846.7	710.8	135.8
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан АХ-дад төрөөс үзүүлэх дэмжлэг	717.9	675.7	42.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	570.5	237.9	332.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,539.8	9,285.7	6254.1
Барилга байгууламж	13,530.6	6,717.2	6813.4

Их засвар		519.3	-519.3
Тоног төхөөрөмж	2,009.2	2,049.3	-40.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,036.3	65,276.3	6760.0
Улсын төсвөөс санхүүжих	28,126.7	27,338.5	788.2
Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,858.8	35,816.2	2042.6
НДС-ийн төсвөөс санхүүжих			0.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	810.2	1,821.8	-1011.6
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих			0.0
Бусад эх үүсвэр	5,240.6	299.8	4940.8

2018 оны 09 сарын 30-ны байдлаарх төсвийн хэмнэлт дараах шалтгаануудаас үүдэлтэй байна. Үүнд:

- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 192.3 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь 3-р улирлын үр дүнгийн урамшууллын хуваарь 9-р сард тавигдсантай холбоотой байна. Үр дүнгийн урамшууллыг 10 сард олгогдсон. Мөн ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл үр дүнгийн урамшуулал олгоогүйгээс шалтгаалж 19.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 544.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байгаа нь дулааны зардлын хуваарийг 12 сард жигд тавигдсантай холбоотойгоор үүссэн байна.
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 110.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн шалтгаан нь ТАХ-д олгох 300.0 мянган төгрөгийн урамшуулал 10-р сараас хасагдаж цалин, хөлсний зардал руу нэмэгдэх болсонтой холбоотой байна ,
- Тэтгэвэрт гарах нас нь болоогүй хүмүүсийн тэтгэмж 8, 9-р сарууд дээр тавигдсан, Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 135.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байгаа нь тэтгэвэрт гарах албан хаагчдын тэтгэвэрт гарах сар болоогүй байсантай холбоотой байна.
- Барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын зардал 6,254.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь тендер зарлагдаагүй болон гүйцэтгэл нь гараагүй ажлуудыг санхүүжүүлээгүйтэй холбоотой хэмнэлт үүсчээ.

Аймаг, сумдын ЗДТГ-уудын 2018 оны 09 сарын байдлаарх төсвийн зарлагын гүйцэтгэлийг шалгахад дараах зөрчлүүд гарлаа. Үүнд:

- Жаргалант сумын ЗДТГ-аас сумынхаа 40 жилийн ойн баяр наадамд зориулж 0.9 сая төгрөгийг Улаантолгой хөгжил ТББ-д хандивласан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 25.10 дахь “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Жаргалант сумын Засаг даргын тамгын газар тээвэр, шатахууны зардлаас зарцуулагдах ёстой 0.25 сая төгрөгийн шатахууны зардлыг бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан байна.
- Баян-Өндөр сумын ЗДТГ нь “БСБ ЛЮКС МЕБЕЛЬ” ХХК-аас 15 ширхэг принтерийн хорыг нийт 0.9 сая төгрөгөөр худалдан авсанаар баримтаа

бүрдүүлж, төмөр сеф худалдан авсан байна. Тухайн төмөр сеф байгууллагын хөрөнгөнд бүртгэлгүй байна

- “Очир пресс” ХХК-д ирсэн явсан бичгийн хэвлэлийн зардалд 0.9 сая төгрөг, “Экспресс дизайн” ХХК-д принтерийн хорны зардалд 0.6 сая төгрөг шилжүүлсэн байна. Бодит байдал дээрээ “Үг ухаан төрүүлдэг” хэмээх номыг хэвлүүлсэн байна.

Баян-Өндөр сумын ЗДТГ-т хуурамч баримт бүрдүүлэн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан 2.4 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

- Засгийн газрын 1999 оны 84 дугаар “Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт, зардлын норматив батлах тухай” тогтоолыг ЗГ-ын 2016-11-16-ны өдрийн 141-р тогтоолоор хүчингүй болгосон байтал 2018 оны 09 сарын байдлаар аймгийн Засаг даргын утасны төлбөр 1.2 сая төгрөгийг шуудан холбоо болон мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас тус тус гаргасан байна.
- 2018 оны 09 сарын байдлаар аймгийн ЗДТГ-ын тусгай зориулалтын материалын дансанд нийт 1074 ширхэг 17.4 сая төгрөгийн өртөгтэй ямарч ашиглалтгүй ном бүртгэлтэй байгаа бөгөөд 2018 оны 06 сард “Алтан соёмбын эзэд эх орны эрхэм” нэртэй 100 ширхэг номыг нийт 3.0 сая төгрөгөөр худалдан авсан байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-т “Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 8.7.1-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэсэн заалтуудыг зөрчин 51 ширхэг 26.4 сая төгрөгийн өртөгтэй зэс домбо, зэс аягыг, 11.5 сая төгрөгийн принтерийн хорыг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХ болон хүчингүй болсон ЗГ-ын тогтоолыг үндэслэн зардал гаргасан 3 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХАТ хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2018 оны 3-р улирлын байдлаар нийт 25.8 тэрбум төгрөгийн 164 төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд:

- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11.2 тэрбум төгрөгийн 133 бараа, ажил, үйлчилгээ,
- Улсын төсвөөс эрх шилжиж ирсэн 10.3 тэрбум төгрөгийн 7 бараа, ажил, үйлчилгээ,
- Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар, Боловсрол, соёл урлагийн газруудын захиалгаар 2.5 тэрбум төгрөгийн 17 бараа, ажил, үйлчилгээ,
- Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 1.6 тэрбум төгрөгийн 6 бараа, ажил, үйлчилгээ

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт:

2018 оны 3-р улирлын байдлаар Орон нутгийн өмчийн газрын 25.8 тэрбум төгрөгийн 164 төрлийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл:

- Шалгарч гэрээ байгуулсан-147
- Судлагдаж байгаа-1
- Зураг төсөв, техникийн тодорхойлолт хүлээгдэж буй-5
- Амжилтгүй болсон-8 /шаардлага хангасан тендер ирээгүй/
- Зарласан -3 худалдан авалт байна.

Нийт худалдан авалтын 89.6 хувь нь шалгарсан, 0.6 хувь нь худалдан авалт хийгдэхээр судлагдаж байгаа, 3 хувь нь зураг төсөв, техникийн тодорхойлолт хүлээгдэж буй, 1.8 хувь нь зарласан байна. Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 89.6 хувийн биелэлттэй байна.

Эрх шилжиж ирсэн ажлуудын худалдан авах ажиллагааны биелэлт:

Улсын төсвөөс эрх шилжиж ирсэн 10.3 тэрбум төгрөгийн 7 ажил байна. Үүнд: Барилга хот байгуулалтын яамнаас 3.5 тэрбум төгрөгийн 2, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас эрх шилжиж ирсэн 6.8 тэрбум төгрөгийн 5 ажил тус тус эрх шилжиж ирсэн.

Нийт эрх шилжиж ирсэн 7 ажлаас 2 ажлын зураг төсөв хүлээгдэж буй, 5 ажил нь шалгарч гэрээ байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01 оны өдрийн 9/04 дугаар тогтоолоор “Аюулгүй ажиллагааны төв, авто тээврийн хяналтын камерын нэгдсэн төвийг шилжүүлэх зардал” их засварын ажлыг 300.0 сая төгрөгөөр баталсан.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 сарын 28-ны 59 дүгээр тогтоолоор тухайн ажлыг төсөл хөтөлбөр рүү шилжүүлэх тогтоол гаргажээ. Уг тогтоолд шилжүүлсэн зардлын өөрчлөлтийг аймгийн ИТХ-аар баталгаажуулах, зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргад үүрэг болгосон байсан. ИТХ-аар баталгаажуулсан шийдвэр гараагүй тул гүйцэтгэгч компанийн 2018 оны 08 сарын 15-ны өдрийн ажлын гүйцэтгэл, нэхэмжлэлийг үндэслэн 2018 оны 10 сарын 05-ны өдөр 105.5 сая төгрөгийн санхүүжилтыг хөрөнгө оруулалтын данснаас олгосон байна.

Дээрх 300.0 саяын өртөг бүхий ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.” гэсэн заалтыг зөрчин шууд гэрээ байгуулсан.

Төсвийн тухай хуулийн 4.1.24-т “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”; 4.1.27-д “орон нутгийн төсөв” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг”; гэсэн заалтуудыг зөрчиж орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн 8 байгууллагад хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 996.4 сая төгрөгийн дэмжлэг

үзүүлсэн байна. Иймд улын төсвийн байгууллагууд нэн түрүүнд шаардлагатай байгаа их засвар болон тоног төхөөрөмжийн зардлыг харьяалах дээд шатны байгууллагадаа уламжлан төсвийн төсөлдөө тусган батлуулж ажиллах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагаа урьдчилан судалж, үнэлж, нэн тэргүүний шаардлагатай төсөл арга хэмжээг тодорхойлох, зөвхөн санхүүгийн дэмжлэг хүссэн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх бус зорилго зорилттойгоо нийцүүлэх, үр ашиг, үр нөлөөг нь тооцож төлөвлөж, зарцуулах шаардлагатай байна.

Засаг даргын нөөц сан.

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.2-т “Засаг даргын нөөц хөрөнгийг орон нутгийн төсөвт нийт дүнгээр тусган тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын нөөц сангийн төсвийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар 500.0 сая төгрөгөөр баталсан байна.



Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1, 2.1.2-т заасан арга хэмжээнүүдэд 5.4 сая төгрөг зарцуулсан байгаа нь нийт зардлын зөвхөн 2 хувийг л эзэлж байна. Үлдсэн 98 хувийг журмын 2.1.3-т “Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх.” гэсэн заалтад хамааруулсан байна.

Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй санхүүжилт гаргах шаардлагатай зарим зардлыг санхүүжүүлэх болон тухайн шатны Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх зориулалт бүхий Засаг Даргын нөөц хөрөнгийг дараах шаардлагагүй зардалд зарцуулсан байна. Үүнд:

- Улс төрийн бодлогын орон тооны бус зөвлөхөд 2.5 сая төгрөгийн урамшуулал, орон тооны бус зөвлөхүүдэд 1.1 сая төгрөгийн урамшуулал,
- Тамгын газрын даргыг Филиппин улсад 5 хоногийн сургалтанд хамрагдахад 4.4 сая төгрөг,
- Зочин төлөөлөгч хүлээн авах зардалд-23.3 сая төгрөг,
- Жаргалант сумын засаг даргын нөөцөөс 0.3 сая төгрөгөөр авто машины сэлбэг худалдан авсан,
- Жаргалант сумын нөөц сангийн хөрөнгөнөөс 0.1 сая төгрөгөөр архи худалдан авч, зарцуулсан байна. / Энэ нь архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.9 дэх “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон.

Орхон аймгийн Засаг даргын нөөц сангаас урьдчилан төлөвлөх, төсвийн байгууллагуудын төсөвт тусгаж батлагдах бололцоотой 37.6 сая төгрөгийг дэмжлэг хэлбэрээр гаргасан байна. Үүнд:

- Оюут багийн цагдаагийн өрөөг засварлахад- 3.4 сая төгрөг,
- Статистикийн хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд-2.2 сая төгрөг,
- Татварын хэлтсийн Улаан-Үд хотын татварын албатай танилцах аялалын зардалд-5.0 сая төгрөг,
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сувилал, техникийн ажиллагсад, үйлчлэгч нарын шөнийн ээлжинд халуун хоолоор хангахад санхүүгийн дэмжлэг үзүүлж 27.0 сая төгрөг,

Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 5.1-д “ Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.” гэсэн заалтыг зөрчин 15.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал гарсан тул албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Орхон аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд задлан шинжилгээний иж бүрдэл багаж худалдан авахад-3.5 сая төгрөг, суурин компьютер худалдан авахад 2.5 сая төгрөг,
- Бүсийн оношлогоо эмчилгээний төвд хөргөлтийн төхөөрөмж худалдан авахад 0.8 сая төгрөг, агаар сэлгэх тоног төхөөрөмж худалдан авахад 2.5 сая төгрөг,
- Хотын захирагчийн албанд принтер худалдан авах зардалд-5.7 сая төгрөг,

Аймгийн Засаг даргын нөөцийн сангийн зарцуулалтыг төрөл зүйлээр нь ангилахад дараах байдалтай байна.



2018 оны 09 сарын байдлаар батлагдсан нөөц сангийн хөрөнгийн 7 хувийг зочин төлөөлөгч хүлээн авахад, 8 хувийг өмнөх оны өглөгт, 27 хувийг байгууллагад дэмжлэг үзүүлэхэд, 1 хувийг буцалтгүй тусламжинд, 9 хувийг шагнал, урамшуулалд, 46 хувийг бусад зардалд зарцуулж байгаа нь нөөц сангийн журмын 2.3-т "Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн 30-аас доошгүй хувийг нөөцөд байлгаж журмын хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

2018 онд ОНХС-аас олгох аймаг, сумын орлогын шилжүүлгийг 3504.9 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХС-аас хөрөнгө оруулалтын зардалд 1545.1 сая төгрөг, Хот тохижуулах газрын урсгал зардалд 384.8 сая төгрөг, мал эмнэлгийн үйлчилгээний урсгал зардалд 38.8 сая төгрөг нийт 1968.3 сая төгрөг, Баян-Өндөр суманд 783.6 сая төгрөг, Жаргалант суманд 752.4 сая төгрөг зарцуулахаар батлагдсан.

2018 оны хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдэх тодотгосон хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний жагсаалтанд шилжих хөрөнгө оруулалтаар 137.2 сая төгрөгийн өртөгтэй 14 ажил хийгдэхээр АИТХ-аар баталсан байна. Үүнээс 4.6 сая төгрөгийн өртөгтэй 4 ажил хийгдэж, санхүүжилт олгогдсон байна.

Шинээр эхлэх хөрөнгө оруулалтаар 1,445.5 сая төгрөгийн 3 ажил хийгдэхээр АИТХ-аар батлуулсан ба 2018 оны 09 сарын 30-ны байдлаар 2 ажлын 824.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн тухайд.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9 дүгээр хуралдааны 9/04 дүгээр тогтоолоор аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтанд 1,445.1 сая төгрөгийн өртөгтэй 3 ажил, аймгийн баяр наадмын зардалд 100.0 сая төгрөг тус тус батлагдсан байна.

Орхон аймаг Улсын баяр наадмын зардалд 100.0 сая төгрөг, Жаргалант сум 12.0 сая төгрөг тус тус зарцуулж баяр наадмын зардлыг нийт 97.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолд улсын баяр наадмын санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 сая төгрөг, суманд 5.0 сая төгрөг байхаар тогтоосныг зөрчсөн байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг газар дээр нь үзэхэд дараах байдалтай байна.

Төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараа ямар байгууллага эзэмшиж ашиглах, үйл ажиллагааны зардлыг ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх талаар урьдчилан судлаагүйгээр дараах төсөл арга хэмжээнүүдэд ИТХ-аар төсөв батлуулж Төсвийн тухай хуулийн 29.2-т “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна” заасан заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Жаргалант сумын жаргалант багт байрлах 117.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Халуун усны барилгыг 2016 онд улсын комисс ашиглалтанд хүлээлгэн өгсөн боловч өнөөг хүртэл сум орлогодоо аваагүй, чанаргүй хийгдсэн гэсэн шалтгаанаар хөрөнгийн ашиглагч байгууллага тодорхой бус, ашиглалтгүй байгаа бөгөөд мөн 2018 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар ашиглалтын зардлыг тодорхойлолгүй Улаантолгой багт 141.8 сая төгрөгөөр халуун усны барилга бариулж эхэлсэн байна. Тухайн халуун усны газрын гүйцэтгэгчээр “Хөрөнгийн бэл” ХХК шалгарч 2018 оны 07 сарын 06-ний өдөр хуанлийн 90 хоногт багтаан ашиглалтанд оруулахаар гэрээ байгуулсан боловч гэрээт ажлын хугацаа дууссан байхад гүйцэтгэл 70 орчим хувьтай явагдаж байна.



Зураг 1. Усан сангийн худаг



Зураг 2. Одоо баригдаж байгаа халуун усны барилга-Жаргалант сум

- Жаргалант сумын спорт заалыг 2016 онд хүлээн авч 2017 оноос ашиглалтанд оруулсан хэдий боловч ашиглалтын зардлыг тодорхойлоогүй

байснаас шалтгаалж ОНХС-ын хөрөнгөөр урсгал зардлыг санхүүжүүлсэн байна. Тухайн спорт заалны 7 ажилтны 2018 оны 1-3 сарын цалин 8.0 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжүүлсэн байна.

Иймд ашиглалтын зардлыг тодорхойлсны үндсэн дээр үр ашиг, үр өгөөжтэй төсөл арга хэмжээг төлөвлөх хэрэгтэй байна.

- “Шинээр худаг гаргах /Зүүн булаг/ ажил”-ын байршлыг өөрчилсөн тогтоол гараагүй байхад баруун булагт худаг барих ажлыг эхлүүлсэн байна. Баруун булагт хийгдэж байгаа худаг гаргах ажил 2018 оны 05 сарын 14-ны өдрөөс эхлэн 07 сарын 05-нд хийгдэж дуусахаар гэрээнд заасан боловч өдийг хүртэл ажил дуусаагүй байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ын хөрөнгөөр хийгдэх ТАХ-ны жагсаалтанд яргуйт багийн толгодын 32-р гудамжны шороон зам сайжруулах ажил батлагдсан байна. 32-р гудамжны шороон зам сайжруулах ажил 2017 онд хийгдсэн байсан тул оронд нь 35-р гудамжийг зассан байна.



Зураг 3. Толгодын 32-р гудамж



Зураг 4. Толгодын 35-р гудамж

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана.” гэж заасныг зөрчсөн байна.

Бүлэг 4. ТЕЗ-ын төсөл, хөтөлбөрүүдийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлтэй нийцүүлэн баталсан хэдий ч хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

4.1. Аймгийн 2018 оны төсвийг батлахдаа ТЕЗ-ийн хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж, төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулаагүй байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 сарын 01-ний өдрийн 9/04 дугаар тогтоолоор аймгийн 2018 оны төсвийг батлахдаа ТЕЗ-ийн хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж, төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулаагүй

байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 33.2.5-д “төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар;”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан 7.5.6-д “аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж, дараахь зүйлийг тусгана:” 7.5.6.в/”тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт;”, 7.5.6.г/ “тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт;” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ИТХ-аар 2018 онд 6,286.6 сая төгрөгийн 147 төсөл, хөтөлбөр хэрэгжихээр батлагдсан. Энэ нь 2018 онд санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 33.1 хувийг эзэлж байна.

4.2 ТЕЗ-ын төсөл, хөтөлбөрүүдийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлтэй нийцүүлэн баталсан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.а, 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсан байна. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнадаг байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн биелэлт 61.9 хувьтай байна.

2018 онд 6,286.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 147 төсөл хөтөлбөр хэрэгжихээр батлагдсанаас оны эхний 9 сарын байдлаар 4,171.7 сая төгрөг зарцуулагдаж гүйцэтгэл 66.3 хувьтай байна.

Төсөл, хөтөлбөрийг зохицуулсан тушаал шийдвэр байхгүй байна. Цаашид төсөл хөтөлбөрийн зарцуулалтыг журамлах шаардлагатай байна.

- Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар 2018 онд хөрөнгө оруулалтаар 3 ТАХ, тоног төхөөрөмж 2, төсөл хөтөлбөрөөр 36 ТАХ нийт 41 ТАХ батлагдан хэрэгжиж байна. Баян-Өндөр уулын 5-р хэсэглэлийн 32-р ялгарлын 4.9 га талбайн таримал ойн төгөлийн хамгаалалтын хашаа барих ТАХ-г Булган трейд ХХК хэрэгжүүлж дууссан. Талбайн хэмжээг багасган 1.9 га талбайг хашаажуулсан баталгааг аваагүй санхүүжилтийг бүрэн олгосон нь барилгын тухай хуулийн 14.8-д “Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу зохицуулна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах эрхийг хангасан байгальд ээлтэй ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, ногоон соёлыг хөгжүүлэх Орхон аймагт жишиг “Эко” ажлын байр бий болгох төслийг НДХ хэрэгжүүлэхээр төсөл бичсэн байна. Тухайн төслийн зорилго нь хэлтэсдээ тоног төхөөрөмж авахад чиглэгдсэн байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийн 36 ТАХ-с огт хэрэгжээгүй 9 ТАХ үлдсэнээс, 2 ТАХ-ний нэр өөрчлөгдсөн байна.

4.3 Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

2018 оны 09 сарын байдлаар хөтөлбөр арга хэмжээний зарцуулалтанд тухайн төсөл хөтөлбөрийн харьяалагдах хэлтэс газрууд нь анхан шатны баримтын бүрдэл болон хэрэгжилтийг хянан дүгнэж, санхүүжилт олгох эрхийг өгч ажиллаж байна. Хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэлд хяналт хангалтгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2018 оны 02 сарын 23-ны өдрийн 10/02 тоот тогтоолоор батлагдсан орон нутгийн төсөвт хийсэн тодотгол нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг зөрчсөн байна.
- Сангийн ямаар хянагдаж, УИХ-аар батлагдсан орон нутгийн орлогыг 134.6 сая төгрөгөөр, зарлагыг 1,563.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.
- Төсвийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн худалдан авалт болон хөрөнгө оруулалтыг аймаг орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн ч төсөв батлагдсанаас хойш 183.1 сая төгрөгийн 12 ТАХ-ний зураг төсөв хийгдсэн байна.
- Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХАТХуулийн зарим заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
- Замын цагдаагийн бэлэн бус торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.
- Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн ИТХ-ын анхааралд толилуулах нь:

1. Орон нутгийн төсвийн тодотголыг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасан нөхцөл бий болсон тохиолдолд орон нутгийн төсөвт тодотгол хийхийг зөвлөж байна.

САГ-2018/02-СА

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ЯВЦ

Аймгийн Засаг дарга, Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Батлут, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Бямбацэцэг нарт:

1. Орлогыг тооцоо судалгаатайгаар боломжит нөөц боломжоор бүрэн хамруулан төлөвлөж биелэлтийг ханган, бэлэн бус торгуулийн системээр ноогдуулсан торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн оруулах биелэлтэд тавих хяналтыг сайжруулах.
2. Улирал бүр Засаг даргын нөөц сангийн 30-аас доошгүй хувийг дансанд үлдээж, төсвийн байгууллагуудын төсөвт тусгаж батлагдах бололцоотой зардлуудыг засаг даргын нөөц сангаас гаргахгүй байх.

Аймгийн Засаг дарга, Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Батлут, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Бямбацэцэг, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ц.Баяржаргал нарт:

1. Хөрөнгө оруулалтын ажлыг бодитой төлөвлөж, хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар гаргаж, шинээр ашиглалтанд орох үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргаж байх


Үндэсний Аудитын газарт санал:

1. Төсөл, хөтөлбөрийн зарцуулалт нь журмаар зохицуулагдаагүй тул олон төрлийн урсгал зардлыг гарган, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа тул цаашид журамлах шаардлагатай байна.
2. Засгийн газраас Улсын баяр наадмын санхүүжилтийн аймаг сумын жишиг дээд хэмжээг бодит байдалд нийцүүлж, батлах
3. Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь "Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх." заалтыг тодорхой болгож журамд өөрчлөлт оруулах.

АУДИТЫН МЕНЕЖЕР  Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР

 Б.БУЯН-УНДРАХ
 О.ГАНТУЯА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН САНАЛ:

**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон,
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
И-мэйл: info@erdenet.mn

2018.11.05 № 6/2812
танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн
явц” аудитын тайлантай танилцлаа.

Уг тайлангийн төсөлд нэмэх саналгүй,
аудитаар ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах
болно.



САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.БЯМБАЦЭЦЭГ

D:/My documents/A-5. doc

0301806825



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 1130

Эрдэнэт хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовн 2017 оны А/188 дугаар тушаал, 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц"-д хийсэн аудитын тайлан /САГ-2018-02-СА/-г баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөрчлийн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Соёлчхүү/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Н.Бямбацэцэг/ нарт зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, аудитор /Б.Буян-Ундрах, О.Гантуяа/ нарт даалгасугай.


ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



D:\my doc \bichig hereg\ tushaal \ 2018.doc

070058

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Төргүүлэх аудиторын 2018 оны 11 дүгээр
сарын 05-ны өдрийн 30 дугаар тушаалын
хавсралт



“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” аудитаар илэрсэн
төлбөр, зөрчлийн жагсаалт

/сая.төгрөг/

Актын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төл бөр	Зөрч ил
			Албан тушаал	Нэр		
57/60- САГ- 2018-02- СА	Жаргалант сумын нөөц сангийн хөрөнгөнөөс архи худалдан авч, зарцуулсан байна.	Жаргалант сумын ЗДТГ	Дарга Нягтлан бодогч	Т.Энхжаргал С.Анхзул	0.1	.
70/78- САГ- 2018-02- СА	Аймгийн ЗДТГ-ын үндсэн данснаас 2018 оны 09 дүгээр сарын байдлаар аймгийн Засаг даргын утасны төлбөр 1.2 сая төгрөгийг шуудан холбоо болон мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас гаргасан, 2018 оны 06 дугаар сард “Алтан соёмбын эзэд эх орны эрхэм” нэртэй 100 ширхэг номыг нийт 3.0 сая төгрөгөөр худалдан авсан, 51 ширхэг 26.4 сая төгрөгийн өртөгтэй зэс домбо, зэс аягыг, 11.5 сая төгрөгийн принтерийн хорыг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулсан байна.	Аймгийн ЗДТГ	Дарга Нягтлан бодогч	Д.Соёлчхүү Л.Дуламжав		42.1

71/79- САГ- 2018-02- СА	Баян-Өндөр сумын ЗДТГ нь "БСБ ЛЮКС МЕБЕЛЬ" ХХК-аас 15 ширхэг принтерийн хорыг нийт 0.9 сая төгрөгөөр худалдан авснаар баримтыг бүрдүүлж, төмөр сейф худалдан авсан, "Очир пресс" ХХК-д ирсэн явсан бичгийн хэвлэлийн зардалд 0.9 сая төгрөг, "Экспресс дизайн" ХХК-д принтерийн хорны зардалд 0.6 сая төгрөг шилжүүлсэн байна. Бодит байдал дээрээ "Үг ухаан төрүүлдэг" хэмээх номыг хэвлүүлсэн байна.	Баян-Өндөр сумын ЗДТГ	Дарга Нягтлан бодогч	Ш.Өлзийбаяр А.Адъяадолжин		2.4
72/80- САГ- 2018-02- СА	Орхон аймгийн Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд задлан шинжилгээний иж бүрдэл багаж худалдан авахад 3.5 сая төгрөг, суурин компьютер худалдан авахад 2.5 сая төгрөг, Бүсийн оношлогоо эмчилгээний төвд хөргөлтийн төхөөрөмж худалдан авахад 0.8 сая төгрөг, агаар сэлгэх тоног төхөөрөмж худалдан авахад 2.5 сая төгрөг, Хотын захирагчийн албанд принтер худалдан авахад 5.7 сая төгрөг тус бүр зарцуулсан байна.	Аймгийн ЗДТГ	Дарга Нягтлан бодогч	Д.Соёлчхүү Л.Дуламжав		15.0
Нийт дүн					0.1	59.5

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61000 Эрдэнэт хот, Амарын талбай,
УБД 2070001050, Нутгийн удирдлагын ордон
Утас/Факс: 70359826
E-mail: orkhon@audit.gov.mn

2018. 11. 05 № 191
танай _____ -ны № _____ -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

"2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц" /САГ-2018-02-СА/, "Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн" /САГ-2018-03-СА/ аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт..... хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



D:\my doc \ bichig heregl\ alban bichig\ 2018-A5.doc